



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/27

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулж, нийтэд мэдээлэх” сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайлан болон нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг www.open.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: АЙМАГ, СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛЖ, НИЙТЭД
МЭДЭЭЛЭХ



Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитор Д.Чулуунцэцэг
Утас: 70362442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn
Аудитор Ж.Баясгалан
Утас: 70362442 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Open.audit.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын нам
АН	Ардчилсан нам
ИХН	Иргэний хөдөлгөөний нам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудитын нэр:

Аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулж, нийтэд мэдээлэх.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлнэ.

3. Аудитын зорилт:

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэх.

4. Аудитын хамрах хүрээ:

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд өгсөн аудитын дүгнэлт, дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга болон бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

5. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан *“Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг* үндэслэн нэр дэвшигчийн өөрийн болон намаас оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив, түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйлсийг цуглуулж, тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл:

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 30 тойрогт 3 намаас 92 нэр дэвшигч, 2 бие даагч зэрэг нийт 94 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Намын нэр	Нам	Нэр дэвшигчид /тоо/
1	МАН	1	41
2	АН	1	41
3	ХҮН	1	10
4	Бие даан нэр дэвшигч		2
Нийт		3	94

17 сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн 57 тойрогт 3 намаас 787 нэр дэвшигч, бие даагч 10 зэрэг нийт 797 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна.

Үүнд:

Д/д	Намын нэр	Нам	Нэр дэвшигчид
1	МАН	1	383
2	АН	1	377
3	ИХН	1	27
4	Бие даан нэр дэвшигч		10
Нийт		3	797

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 891 нэр дэвшигчдээс Аймаг, Нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу 34 нэр дэвшигч нь аймаг, сумын ИТХ-д давхар нэр дэвшсэн байна. Үүнээс сонгуулийн зардлын тайланг ирүүлсэн 856 нэр дэвшигчийн дансанд нийт 607,984.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 607,775.0 мянган төгрөг зарцуулж, харилцах дансанд 209.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бол 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

Аймаг, сумдын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 4 намаас МАН сонгуулийн зардлын дансандаа 25,000.5 мянган төгрөгийн мөнгөн хандив төвлөрүүлсэн байна.

Сонгуульд оролцсон 856 нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлогыг задалж харуулбал:

- 22 хуулийн этгээдээс 68,956.4 мянган төгрөгийн,
- 602 иргэнээс 379,023.1 мянган төгрөгийн,
- 6 иргэнээс 1,600.0 мянган төгрөгийн мөнгөн бус хандив өгсөн бол нэр дэвшигчид өөрсдөөс 158,405.4 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/11 дугаар тушаалаар” Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээ”-г тогтоон нийтэд мэдээлсэн бөгөөд уг хэмжээг нам, нэр дэвшигчид хэтрүүлээгүй байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн

зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд нийт оролцсон 857 нэр дэвшигч / давхардлыг хасаж тооцсон/ 4 нам ирүүлэх үүрэгтэй. Тайлант хугацаанд 4 намын 840, бие даагч 12 нэр дэвшигч дансаа ирүүлсэн бол аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд давхар өрсөлдсөн 34 нэр дэвшигч зардлын 1 данс нээлгэж, 1 нам, 4 нэр дэвшигч хандивын данс огт нээлгээгүй байна.

Харин Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Ерөө сумын 4-р тойрогт ХҮН-аас нэр дэвшигч Пүрэвцэрэнгийн Ундрам нар нь сонгуулийн зардлын дансны мэдээллээ огт ирүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “ Нам эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байдаг.

Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцсон 856 нэр дэвшигч , 4 нам зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлтээ хуулийн хугацаанд бүрэн ирүүлсэн бол Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 4-р тойрогт ХҮН-аас нэр дэвшсэн Пүрэвцэрэнгийн Ундрам нар нь зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлтээ ирүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын данс нээлгэсэн 856 нэр дэвшигч, 3 намын дансны хуулгыг ХААН, Голомт, Төрийн банк бүрэн ирүүлсэн байна.

Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж ирүүлсэн 856 нэр дэвшигч, 4 намын тайлангаас 278 нь орлого төвлөрүүлээгүй, зарлага тайлагнаагүй, “Х” тайлан байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 607,984.9 мянган төгрөгөөс 606,384.9 мянган төгрөг нь мөнгөн хандив байгаа бол 1,600.0 мянган төгрөг нь мөнгөн бус буюу үнэ төлбөргүй ухуулагчаар ажилласан хандив байна. Үүнд:

Орлогын төрөл	Орлого /мянган төгрөг/				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	4	1,400.0			4	1,400.0
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	435	158,405.4			435	158,405.4
Хуулийн этгээдийн хандив	21	67,556.4			21	67,556.4
Иргэний хандив	602	379,023.1	6	1,600.0	608	380,623.1
Дүн	1062	606,384.9	6	1,600.0	1068	607,984.9

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдэд 63 иргэнээс 163,184.1 мянган төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандивыг, 7 хуулийн этгээдээс 53,836.3 мянган төгрөгийн хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандивыг өгсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1,2-т харуулав/

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 607,775.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 556,771.6 мянган төгрөг, бусад зардалд 51,003.4 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

Зардлын ангилал			Мөнгөн дүн / мянган төгрөг/
Нийт зардлын дүн			607,775.0
2.1	Сонгуулийн зардлын дүн		556,771.6
	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	102,430.5
	2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	7,094.2
	2.1.3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-
	2.1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	949.4
	2.1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал / Ухуулах байрны түрээс, ухуулагчийн цалин, тээвэр шатахуун, томилолт... гэх мэт /	441,245.5
	2.1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	2,000.0
	2.1.7	Цахим орчин ашиглах зардал	412.0
	2.1.8	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	2,640.0
2.2	Бусад зардлын дүн / сонгуулийн сурталчилгааны нээлт хаалтын зардал, ухуулагчдын хоолны зардал, банкны гүйлгээний шимтгэл, данс хаах шимтгэл... гэх мэт /		51,003.4

Намууд /МАН/-ын сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 25,005.5 мянган төгрөгийн хандив байна. Үүнд:

Орлогын төрөл	Орлого /мянган төгрөг/				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө						
Хуулийн этгээдийн хандив						
Иргэний хандив	14	25,000.5			14	25,000.5
Дүн	14	25,000.5			14	25,000.5

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намууд /МАН/-д 14 иргэнээс **25,000.5** мянган төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандивыг өгсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-т харуулав/

Намын сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 25,000.5 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 25,000.0 мянган төгрөг, бусад зардалд 0.5 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

Зардлын ангилал			Мөнгөн дүн / мянган төгрөг/
Нийт зардлын дүн			25,000.5
2.1	Сонгуулийн зардлын дүн		25,000.0
	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	25,000.0
	2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	-
	2.1.3	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	-
	2.1.4	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	-
	Бусад зардлын дүн		0.5

8. Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандив:

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид нь хандив өгч буй иргэн, хуулийн этгээдийн нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай 733 иргэн, хуулийн этгээдийн 180,901.2 мянган төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандив тайлагнасан байна.

Үүнээс 683 иргэн, хуулийн этгээдийн 165,888.2 мянган төгрөгийн хандивыг буцааж, 50 нэр дэвшигчид иргэдээс өгсөн 15,013.0 мянган төгрөгийн хандивыг зарцуулсан байна.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан *“Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”*-ын дагуу аудит хийж баталгаажуулсныг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянаж, баталгаажууллаа.

Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангийн аудитаар нийт 15,013.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- 50 нэр дэвшигч хандивлагчийн нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эх үүсвэр тодорхойгүй 15,013.0 мянган төгрөгийн хандивыг зарцуулсан байна.
- 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансанд хийлгэсэн хувийн аудитын дүгнэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

10. Аудитын дүгнэлт:

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцож, сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 4 нам 856 нэр дэвшигчдийн тайланд 5 аудитын хуулийн этгээд дүгнэлт гаргасан байна. Үүнд:

№	Аудитын хуулийн этгээдийн нэр	Дүгнэлт гаргасан тоо		Дүн
		Нам	Нэр дэвшигч	
1	Мэдээлэл аудит Сэлэнгэ салбар	1	306	307
2	Далай ван аудитын Дархан салбар		2	2
3	ЦЭСБ аудит	1	14	15
4	Пийк Ом аудит	2	532	534
5	Баталгаат тооцоолол аудит		2	2
Нийт		4	856	860

Дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээдүүд нам болон нэр дэвшигчдийн зардлын 860 буюу бүх тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлж, дүгнэлт гаргасан байна.

11. Зөвлөмж:

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Х.Мөнхжаргалд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтыг зөрчин сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй аймгийн ИТХ-ын Ерөө сумын 4-р тойрогт ХҮН-аас нэр дэвшигч Пүрэвцэрэнгийн Ундрамд Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.25-д заасны дагуу арга хэмжээ авах.

Аймгийн Татварын газрын дарга Ц.Лхагвадорж-д:

- Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4, 53.5 дахь заалтыг зөрчин, шаардлага хангаагүй хандивын орлогыг буцаалгүй зарцуулсан нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.21-д заасны дагуу арга хэмжээ авах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Д.ЧУЛУУНЦЭЦЭГ
Ж.БАЯСГАЛАН

**Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд
оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн
иргэдийн жагсаалт**

/мянган төгрөг/

1324100015 9055436

№	Аймаг, сумын ИТХ	Намын харьяалал	Нэр дэвшигчийн нэр	Хандив өгсөн иргэний нэр	Хандивын дүн
1	Сэлэнгэ	МАН	О.Дамдинпүрэв	Д.Уртсайхан	2,000,000
2	Сэлэнгэ	МАН	О.Баатарцогт	Д.Чинзориг	1,000,000
3	Сүхбаатар	МАН	Ц.Золзаяа	Ц.Отгонтуяа	1,500,000
4	Сүхбаатар	МАН	Г.Ган-Эрдэнэ	Г.Отгончимэг	2,000,000
5	Сүхбаатар	МАН	Л.Мөнгөнхундага	Л.Батхуяг	2,000,000
6	Сэлэнгэ	МАН	Ж.Сайнцог	Н.Мөнхсүвд	2,000,000
7	Сүхбаатар	АН	Ө.Амартүвшин	Б.Энхчимэг	1,206,000
8	Сүхбаатар	МАН	С.Лхагвадаш	Э.Батзаяа	1,000,000
9	Сэлэнгэ	МАН	Б.Мөнхбат	Б.Мөнхзул	1,000,000
				П.Мөнхсайхан	1,000,000
10	Түшиг	АН	Н.Барамсай	Г.Энх-Амгалан	1,000,000
11	Түшиг	АН	Б.Буянжаргал	А.Эрдэнэбат	1,000,000
12	Сэлэнгэ	МАН	Н.Ариунжаргал	Ц.Оюунчимэг	1,800,000
13	Сүхбаатар	МАН	Э.Баатарцогт	Б.Хатантөмөр	1,000,000
14	Сүхбаатар	АН	Д.Оюундарь	Э.Нарантуяа	1,250,000
15	Сүхбаатар	АН	Б.Бямбаа	Г.Цогзолмаа	1,000,000
16	Мандал	АН	Ш.Ганзул	Я.Хишигжаргал	1,000,000
				Х.Батчулуун	1,200,000
17	Мандал	АН	Б.Хонгорзул	Ж.Нармандах	2,000,000
18	Мандал	АН	Х.Алтаншагай	А.Болдхишиг	1,000,000
19	Мандал	АН	Б.Туул	Б.Гэрэлтуяа	1,000,000
20	Түшиг	АН	Л.Амарсайхан	О.Батцэцэг	1,000,000
21	Сэлэнгэ	АН	Г.Одхүү	Б.Одончимэг	2,000,000
22	Сүхбаатар	МАН	Д.Сансарчимэг	М.Пүрэвдорж	1,000,000
23	Сэлэнгэ	МАН	Г.Дуулга	Б.Батболд	1,000,000
24	Сэлэнгэ	АН	Д.Эрдэнэбаатар	М.Өнөрцэцэг	1,500,000
25	Сэлэнгэ	АН	Ё.Батзул	В.Юүрэнхүү	1,000,000
26	Сүхбаатар	МАН	Б.Гандолгор	П.Сайханчимэг	1,000,000
27	Сэлэнгэ	АН	С.Мэндболд	Ж.Нандинцэцэг	1,000,000
				Д.Отгонтунгалаг	2,000,000
28	Сайхан	АН	Б.Мөнхтөр	Г.Батзориг	1,000,000
29	Хүдэр	ИХН	Д.Баяржаргал	Л.Оюунцэцэг	1,000,000
30	Баруунбүрэн	МАН	И.Цэнд-Очир	И.Наянтай	1,000,000
31	Ерөө	МАН	Б.Батбаатар	Н.Отгонлхагва	1,000,000
32	Ерөө	МАН	Л.Болормаа	Ч.Лувсанцэрэн	1,500,000
33	Сэлэнгэ	МАН	Б.Сэргэлэн	Ц.Цэнгэл	1,000,000
34	Сэлэнгэ	МАН	Н.Захирахбаатар	Х.Нямсүрэн	1,000,000
35	Сэлэнгэ	МАН	Ц.Дарханбаатар	Ж.Цэцгээ	2,000,000
				Ж.Болор-Эрдэнэ	1,000,000
				Х.Цогтбаатар	1,900,000
				Л.Цэрэндорж	1,000,000
36	Мандал	МАН	С.Сувдаа	Э.Хүдэрхүү	1,000,000
37	Мандал	МАН	Ц.Алтанхуяг	Б.Ганболд	2,000,000
				Г.Алтансүх	2,000,000
38	Мандал	МАН	Л.Эрдэнэсайхан	Г.Дашдаваа	1,000,000
				Э.Арьяа	1,000,000
39	Мандал	МАН	Г.Дашдаваа	Г.Ууганболд	2,000,000
40	Мандал	МАН	Э.Баярхүү	Э.Идэрхүү	1,000,000
				Э.Эрдэмсоёл	1,000,000
				Х.Хараа	1,200,000

41	Мандал	МАН	Б.Энхтөр	О.Номинчимэг	1,000,000
				Ж.Цолмон	1,000,000
				Ц.Эрдэнэчимэг	1,500,000
42	Мандал	МАН	А.Цэнд-Аюуш	Л.Ундармаа	1,900,000
				Б.Мөнхболд	1,900,000
43	Мандал	МАН	С.Жаргалцэцэг	С.Төгсбаяр	2,000,000
				Б.Гантулга	2,000,000
44	Мандал	МАН	Н.Эрдэнэцэцэг	Л.Пүрэвдулам	1,500,000
				Э.Оюунболор	1,000,000
45	Мандал	МАН	Ч.Оюунгэрэл	Ц.Ууганцэцэг	1,000,000
				Ж.Саруул	1,000,000
				Х.Үүрийнтуяа	1,000,000
46	Мандал	МАН	Ц.Пүрэвдорж	Д.Буянжаргал	1,500,000
				Б.Хатанбаатар	1,500,000
47	Мандал	МАН	М.Мөнх-Эрдэнэ	Г.Дашдаваа	2,000,000
48	Мандал	МАН	Ю.Ганхуяг	Э.Гэрэлтцацрал	1,200,000
49	Мандал	МАН	Л.Лхагва	Л.Аюушдулам	1,800,000
				Б.Оюунмөнх	2,000,000
50	Мандал	МАН	Б.Удвал	Т.Чинтогтох	1,000,000
51	Мандал	МАН	Б.Энхбаатар	А.Бадам	1,500,000
				Г.Мөнгөнцэцэг	2,000,000
52	Мандал	МАН	Б.Оюунцэцэг	Б.Энхмаа	1,000,000
				Б.Энхмаа	1,355,000
53	Мандал	МАН	Ц.Батболд	Х.Тайшир	2,000,000
				Ч.Элбэг	2,000,000
54	Мандал	МАН	П.Одончимэг	М.Цэгмэд	2,000,100
				Б.Батмагнай	2,000,000
				Ж.Жүгдэр	1,700,000
				Ж.Уранчимэг	1,500,000
55	Мандал	МАН	О.Анар	Б.Ариунаа	1,500,000
				С.Мөнхцэцэг	1,273,000
				Б.Төмөрбаатар	2,000,000
56	Сэлэнгэ	МАН	Т.Сайнжаргал	Б.Цогт	2,000,000
57	Орхон	МАН	Г.Баасансүрэн	Ц.Болортуяа	1,500,000
58	Орхон	МАН	Д.Лхагвадорж	Д.Гэрэлтуяа	1,000,000
59	Сэлэнгэ	МАН	Г.Бат-Орхон	Г.Отгончимэг	2,000,000
60	Сайхан	МАН	С.Чимэдцогзолмаа	Л.Наранбаатар	1,000,000
61	Сайхан	МАН	Ц.Цэрэнханд		1,000,000
62	Сайхан	МАН	Б.Нансалмаа		1,000,000
63	Сайхан	МАН	Б.Алтанхундага		1,000,000
64	Сайхан	МАН	Т.Ганбаатар		1,000,000
65	Сайхан	МАН	О.Мөнхбат		1,000,000
66	Сайхан	МАН	Ц.Цэнгэлжаргал		2,000,000
67	Сайхан	МАН	Г.Анхцэцэг		1,000,000
68	Сайхан	МАН	О.Мягмарсүх		1,000,000
69	Сайхан	МАН	Б.Балжинням		2,000,000
70	Сайхан	МАН	Ц.Нармандах		1,000,000
71	Сайхан	МАН	Б.Долгорсүрэн		1,000,000
72	Сайхан	МАН	Д.Нямбаяр		1,000,000
73	Сайхан	МАН	О.Эрдэнэбаяр		1,000,000
74	Сайхан	МАН	И.Батсуурь		1,000,000
75	Сайхан	МАН	Э.Пүрэвдорж		1,000,000
76	Сайхан	МАН	Б.Батчулуун		1,000,000
77	Сайхан	МАН	Д.Баярбат		1,000,000
78	Сайхан	МАН	М.Наранбаатар		1,000,000
79	Сайхан	МАН	А.Буяндэлгэр		2,000,000
80	Сайхан	МАН	Б.Оюун-Эрдэнэ		1,000,000
81	Сайхан	МАН	М.Оюунбаяр		1,000,000
82	Сайхан	МАН	О.Батзаяа		1,000,000
83	Сайхан	МАН	М.Алтансүх		1,000,000

84	Сайхан	МАН	Л.Балдорж		1,000,000
85	Сайхан	МАН	Б.Эрдэнэтулга		1,000,000
86	Сайхан	МАН	Т.Нямдорж		1,000,000
87	Сайхан	МАН	Б.Чулуун-Эрдэнэ		2,000,000
88	Сайхан	МАН	Л.Ганбаатар		2,000,000
89	Сүхбаатар	МАН	Э.Эрдэнэсайхан	А.Нямсүрэн	1,000,000
90	Сүхбаатар	МАН	Б.Батболд	Н.Ариунбаяр	2,000,000
91	Сэлэнгэ	МАН	М.Тэмүүлэн	Г.Бат-Эрдэнэ	1,000,000
				Г.Ганзориг	1,000,000
92	Сүхбаатар	МАН	А.Дашбат	Л.Наранбаатар	2,000,000
93	Сүхбаатар	МАН	Д.Зоригтбаатар	Т.Чинтогтох	1,000,000
94	Дүн				163,184,100

**Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид хоёр сая ба түүнээс
дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт**



№	Аймаг, сумын ИТХ	Нэр дэвшигчийн нам	Нэр дэвшигчийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн нэр	Хандивын дүн
1	Сэлэнгэ	АН	П.Гончигдорж	Спирт бал бурам ХХК	4,545,454.5
2	Сэлэнгэ	АН	Я.Хишигжаргал	Спирт бал бурам ХХК	4,545,454.5
3	Мандал	АН	Г.Ууганбаяр	Спирт бал бурам ХХК	4,545,454.5
4	Сэлэнгэ	МАН	Г.Дуулга	Өсөх зоос ХХК	10,000,000
				Баялаг энерги ресурс ХХК	10,000,000
5	Мандал	МАН	Н.Баттулга	Алтан заяа жолоо ХХК	3,980,000
6	Сэлэнгэ	МАН	Б.Чимгээ	Элбэг хараа ХХК	2,520,000
7	Сэлэнгэ	МАН	Н.Лхагвадорж	Авга тайж ХХК	8,700,000
8	Сэлэнгэ	МАН	А.Дашбат	Ургац Эрдэнэ ХХК	5,000,000
9	Дүн				53,836,363.6

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2024 оны ээлжит сонгуульд оролцсон намд нэг сая ба түүнээс дээш
төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт



№	Намын нэр	Хандив өгсөн иргэний нэр	Хандивын дүн
1	Аймгийн МАН	М.Шинэчулуун	2,000,000
2	Аймгийн МАН	Г.Бямбаа	2,000,000
3	Аймгийн МАН	Г.Борхүү	2,000,000
4	Аймгийн МАН	Д.Бадарч	2,000,000
5	Аймгийн МАН	Д.Бямбаа	2,000,000
6	Аймгийн МАН	Н.Цэндмаа	2,000,000
7	Аймгийн МАН	Т.Шинэбаяр	2,000,000
8	Аймгийн МАН	Ч.Бадамтуяа	2,000,000
9	Аймгийн МАН	Д.Сэмжид	2,000,000
10	Аймгийн МАН	Ж.Отгонжаргал	2,000,000
11	Аймгийн МАН	М.Даваажаргал	2,000,000
12	Аймгийн МАН	Ч.Оюунтуяа	1,000,000
13	Аймгийн МАН	Ч.Оюун	1,000,000
14	Аймгийн МАН	Э.Эрдэнэчимэг	1,000,500
Дүн			25,000,500